

МОНГОЛ УЛС БА ТОМ ТОГЛОМ



Монгол Улс бол газар зүйн байрлал, орон зайн хувьд хол хэдий ч манай ард түмэнтэй эрт дээр үеэс гүн гүнзгий харилцаа холбоотой байсан, ард олны маань сэтгэл зүрхэнд ойр дотно байдаг улс билээ. ОХУ, БНХАУ-ын дарамт, шахалтаас аль болох бага хамааралтай байх арга замыг эрэлхийлж буй Монгол Улсын хувьд БНТурк улс гуравдагч хөрш байх боломжтой хэдий ч үүний тулд шийдвэрлэх шаардлагатай олон асуудлууд бий.

Турк хэмээх нэрийг түүхэнд анх удаа бичиж үлдээсэн чулуун хөшөө “Орхун Абидэ” Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаг. Хархорин хотын ойролцоох “Билгэ хаан”, нийслэл Улаанбаатар хотын ойролцоох “Тоньюкүкийн хөшөө” зэрэг нь эрт үеийн Турк улсын түүхийг танин мэдэж ойлгоход үнэтэй хувь нэмэр оруулахуйц хосгүй дурсгалууд билээ. Монгол газар нутагт 1300 жил орчим хадгалагдан үлдсэн түүхийн энэхүү үнэтэй дурсгалууд бол Турк улсын Монгол Улстай дотно харилцаатай байх гол шалтгаан, хүчин зүйл боловч хоёр улсын хооронд найрсаг, идэвхитэй хамтын ажиллагаа өрнүүлэхэд түлхэц болсон бусад олон хүчин зүйл бий. Турк болон монгол хэл нь хэл зүйн хувьд нэг аймагт багтдаг бөгөөд өгүүлбэрийн бүтэц адил байдаг. Зарим эх сурвалжид дурдсанаар турк ба монгол хэлэнд утгын хувьд ижил, төстэй 4000 орчим үг, хэллэг байдаг ажээ. Турк болон Монгол Улсын түүхэнд ойролцоогоор 800 орчим жилийн туршид хоорондоо дайн байлдаантай байсан тухай ч тэмдэглэсэн байдаг.

Турк, Монголын ард түмэн хоорондоо ижил, төстэй уламжлал, ёс заншлыг өнөөдрийг хүртэл дагаж мөрдсөөр ирсэн нь олон зуун жилийн турш харилцаа, холбоотой байсны нэг илрэл гэж ойлгож болно.

Олон жилийн турш хуучин ЗХУ-ын нөлөөн дор, коммунист намын удирдлагаар хөгжиж ирсэн Монгол Улс 1990 онд ардчилсан улс төрийн тогтолцоонд шилжиж дараахан нь Улаанбаатар хотод БНТУ-ыг Элчин

сайдын яам байгуулагдаж, улс төр, эдийн засаг, худалдаа, аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагаа идэвхижиж эхэлжээ. Хоёр улс газар зүйн байрлалын хувьд алслагдсан, тээврийн салбар муу хөгжсөн, Монгол Улсын эдийн засгийн чадавхи сул байгаагийн зэрэгцээ ОХУ болон БНХАУ-ын зүгээс тус улсад гуравдагч хөрш оронтой идэвхитэй харилцаа, хамтын ажиллагаатай байх талаар төдийлөн тааламжгүй ханддаг нь хамгийн гол шалтгаан болж байгаагаас хамаараад Турк, Монголын харилцаа хамтын ажиллагаа нэг түвшинд хязгаарлагдаж, тэр хүрээнээсээ ахихгүй байна.

Агаарын тээврээр холбогдох зайлшгүй шаардлага

Өнгөрөгч онд Турк улсаас Монголд экспортолсон барааны нийт хэмжээ 14 сая ам.доллар байв. Монгол Улсаас Турк улсад хийсэн экспортын хувь хэмжээ гэвэл 1 сая ам.доллар байлаа.

Дундад Азийн бүгд найрамдах улсууд руу шууд нислэг хийдэг Туркийн Агаарын Тээврийн компани нийслэл Улаанбаатар хот руу шууд нислэг үйлдэхгүй байгаа нь хоёр улсын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хүссэн түвшинд хөгжүүлэхэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байна. Өнөөдөр Монгол Улс Бээжин, Москва, Токио, Сөүл болон Берлинээр дамжин дэлхийн бусад улс оронтой агаарын тээврээр холбогдож байна. Туркийн Агаарын Тээврийн компани Улаанбаатар хот руу шууд нислэг үйлдэх тохиолдолд Берлиний нислэг ач холбогдолоо алдаж Монгол Улс Европ-Африк-Америк руу агаарын замаар холбогдохдоо Туркээр дамжих шинэ чиглэлийг түлхүү ашиглах магадлалтай юм.

Хоёр талт хамтын ажиллагаанд чухал байр эзэлж буй бас нэг хүчин зүйл бол БНТУ-аас Монголд үзүүлж буй тусламж билээ. Туркийн Олон улсын Хамтын ажиллагааны Агентлагийн /ТИКА/ шугамаар Монгол Улсад үзүүлсэн нийт тусламжийн хэмжээ 21 сая ам.долларт хүрчээ.

Орхоны хөндийн бичээс, хөшөөн чулуу бүхий газар нутагт зам, харилцааг сайжруулах зорилгоор тухайн бүс нутагт нэн тэргүүнд шаардлагатай байсан 46 км урттай Билгэ хаан засмал замыг ТИКА-гийн дэмжлэгтэйгээр барьж 2008 онд ашиглалтанд оруулсан байна. Үүний нэгэн адил Улаанбаатар хотын ойролцоох Тонюкүкийн хөшөө хүрэх 11 км хар замыг тавьж, орон нутгийн төв замтай холбох ажлыг эхлүүлснээр Турк улсын хувьд хосгүй үнэтэй түүхэн дурсгалуудтай газар дээр нь танилцах бололцоо өргөжиж улам хялбар болох юм.

Боловсролын салбарын хамтын ажиллагаа

2009 оны байдлаар Турк улсын Засгийн газрын тэтгэлэгээр их дээд сургуульд суралцагсдын тоо 1000 хүрчээ. Монгол Улсын Их Сургуульд Турк судлалын анги анх 2005 онд нээгдсэн бөгөөд жил бүр 50 орчим оюутан суралцаж төгсдөг байна. Энэхүү Турк судлалын ангийн хичээлийн танхим болон холбогдох бусад зардлыг Туркийн талаас хариуцдаг. Түүнээс гадна Монгол Улсад 6 турк сургууль үйл ажиллагаа явуулж тэдгээрт 1100 орчим хүүхэд суралцаж байна. Тус сургуульд ихэнхдээ боломжтой айлын

хүүхдүүд суралцдаг, анх бүртгүүлэхдээ шалгалт өгч ордог зэргээс үзэхэд тус сургуулийн сургалтын чанар сайн гэдэг нь харагдаж байгаа юм.

Хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас цэргийн сургуулийн оюутнуудыг Туркийн Зэвсэгт хүчний харъяа сургуулиудад суралцах боломж бүрдээд байгаа билээ. Түүнээс гадна БНТУ-ын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн газрын дэмжлэгтэйгээр 2000 онд Монгол Улсын Батлан Хамгаалахын Их сургуульд хэлний лаборатори нээн турк хэл зааж эхэлжээ. Гэсэн хэдий ч турк хэл заах багш хангалтгүй байснаас жилд зөвхөн 1 семестр турк хэл зааж, бусад цагт нь англи хэл заадаг болсон байна. Анги, танхимын тохижилт, лабораторийн тоног төхөөрөмжийг Турк улсаас санхүүжүүлж, Турк улсын далбаа, газрын зураг өлгөсөн тэнхимийг анх байгуулагдсан тэр л зорилгоор нь ашиглах шаардлагатай.

Хорь орчим жилийн хугацаанд олон гэрээ хэлэлцээр, эрх зүйн актад гарын үсэг зурж, эрх зүйн орчинг бүрдүүлж чадсан байтлаа хоёр талт хамтын ажиллагааны цар хүрээ төдийлөн өргөжин тэлж чадахгүй байгаагийн хамгийн гол шалтгаан бол ОХУ болон БНХАУ-ын зүгээс Монголд үзүүлж буй дарамт, шахалт билээ.

Уул уурхайн нөөц баялаг

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд дэлхийн бусад улс оронтой холбогдох бүх гарц хоёр хөрш орноор дамждаг бөгөөд чухамдаа тэдний хяналтанд байхаас өөр аргагүйд хүрдэг. Цөөхөн хүн амтай ч 1,5 сая ам дөрвөлжин метр газар нутаг, зэс, төмөр, уран, нүүрсний баялаг нөөцтэй Монгол Улсын эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал энэ хоёр улсын шууд нөлөөн дор байдаг.

1,4 сая тонны ураны нөөцийг олборлохыг зорьж буй ОХУ-ын зүгээс энэхүү байгалийн баялгийг сонирхож буй бусад орон АНУ, Япон, Франц, Энэтхэгийн компаниудыг тус зах зээлд нэвтрүүлэх тун дургүй байгаа билээ. Энэ их хэмжээний ураны нөөцийг эзэмшигч Монгол Улсад цөмийн эрчим хүчний станц, байгууламж байхгүй. Тус улсын бүх цахилгааны хэрэгцээ нүүрс болон шатах тослох материалаар ажилладаг дулааны цахилгаан станцаар хангагддаг. Монгол Улсад шаардагдах шатахууны 90 хувийг ОХУ-ын Роснефт компаниас худалдан авдаг байна.

ОХУ Монголд 70 жил ноёлсон коммунист дэглэмийн үед бий болгосон хяналтын механизмаа ашиглан энэ улсыг өөрийн “арын гарц, цэцэрлэг” хэмээн үзэж тус “цэцэрлэгт” гадныхны орохыг элдэв аргаар саатуулсаар байна.

Монгол Улсыг түүхийн үүднээс өөрийн нэг хэсэг хэмээн үздэг БНХАУ-ын хувьд тус улсын газар доорх баялгийг сонирхохын зэрэгцээ өөрийн иргэдээ тус улсад маш болгоомжтой, гэхдээ системтэйгээр шилжүүлэн сууршуулахыг оролдож байна. БНХАУ ОХУ-ын нэгэн адилаар Монгол Улсыг аль нэг гуравдагч хөрш оронтой идэвхитэй харилцаа, хамтын ажиллагаатай байхад нь тодорхой хэмжээнд саад тогтор учруулсаар байдаг.

БНХАУ, ОХУ-ын баримталж буй дээрх зарчим, байр суурь Турк улстай харилцах харилцаанд ч тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Тухайлбал, БНТУ-ын санаачлагаар 2008 онд Монгол Улсад хийхээр төлөвлөгдөөд байсан Турк-Монголын хамтарсан цэргийн сургуулилтанд оролцохоор Туркийн цэргийн албан хаагчдыг авч явсан онгоцыг ОХУ өөрийн агаарын хилээр нэвтрүүлээгүйн улмаас энэ арга хэмжээ цуцлагдажээ. Түүнээс гадна БНТУ Монгол Улсын зэвсэгт хүчний харьяа Энхийг Сахилуулах багийнханд шаардлагатай байсан 1 сая ам.долларын өртөг бүхий тоног, төхөөрөмжийг ОХУ, БНХАУ агаарын болон усан хилээр дамжуулан хүргэхээр санал тавсан боловч ОХУ, БНХАУ тагталзсан байна. Энэ мэт техникийн чанартай саад бэрхшээл учирсаар байвал БНТУ, Монгол Улсын хооронд цэрэг, аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагаа дорвитой хөгжихгүй нь ойлгомжтой.

Монгол Улсын төлөөх том тоглоомд оролцогчдын нэг нь христын шашинт номлогчид юм. Тэдний түрүүнд мормон, ехова, эвэнгелист болон хэд хэдэн протестант шашны сүмийн пасторууд орох бөгөөд тэд 1991 оноос хойш тус улсад үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Өнгөрсөн 19 жилийн хугацаанд тус улсад протестант шашны сүм 250 гаруй баригдаж, христын шашин шүтэгчдийн тоо 40000 хүрээд байна. АНУ, Европын орнууд христын шашинт Монголчуудыг ашиглан өөрийн орны нөлөөгөө нэмэгдүүлэх оролдлого хийсээр байна.

Эх сурвалж: Турк Газете сонин, 2010 оны 3 сарын 10, Мягмар гариг

Link : turkiyegazetesi.com.tr

Турк хэлнээс орчуулсан Ч.Цэрэннадмид (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр)